



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/456

Хэрлэн сум

Жуулчны гудамж, мэдээллийн төвийг
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.9, 23.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймагт түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Жуулчны гудамж, мэдээллийн төвийн зураг төсвийг хийлгэж, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд
Чингис хотын Захирагч

Нарийн бичгийн
дарга

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын
дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
дарга

Байгаль орчны газрын дарга

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын
Аялал жуулчлалын албаны дарга

Аймгийн Музейн захирал

Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын захирал

2.Жуулчны гудамж, мэдээллийн төвийг байгуулах ажлыг чанартай өндөр түвшинд хийн зохион байгуулж үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

D:\My Documents\Захирамж-2025

231011313



۲۵۴۲ ۲۵ ۷۷

حضرت محمد و زلمعیرن . یسریس م

Handwritten signature: *Handwritten signature*